



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/518

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Нийтийн орон сууцнуудын орчимд үүссэн хог хаягдлыг цэвэрлэхэд дэмжлэг үзүүлэх”-д зориулан 6 750 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 6 750 000 төгрөг /зургаан сая долоон зуун тавин мянга/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 5.5-д тусгагдсан “Хогны менежментийг сайжруулах арга хэмжээ /Жаргалант сум/” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3.“Нийтийн орон сууцнуудын орчимд үүссэн хог хаягдлыг цэвэрлэхэд дэмжлэг үзүүлэх” зардлыг хавсралтаар баталсугай.

4.Дээрх арга хэмжээг “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль”-ийн хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах, тайлагнах эрхийг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/-д шилжүүлсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/518 Ch
02 02304

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дүгээр сарын 16-ны өдрийн
А/518 дугаар захирамжийн хавсралт.



**“НИЙТИЙН ОРОН СУУЦНУУДЫН ОРЧИМД ҮҮССЭН ХОГ
ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ”
АЖЛЫН ЗАРДЛЫН ЖАГСААЛТ**

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /мян.төг/	Тайлбар
1	Хог цэвэрлэх	хүн	45	150 000	6 750 000	Ховд хотод үйл ажиллагаа явуулж байгаа Сууц өмчлөгчдийн холбоонд нийт 45 үйлчлэгч ажиллаж байгаа бөгөөд дэмжлэг үзүүлэх.
Дүн					6 750 000	

-oOo-